

ГАДНА ЦАХИЛГААНЫ ШУГАМ ТАТАХ, ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

/Нийт үнэд суурилсан/

..... оны .. сарын ... ны өдөр
хот

№:

Улаанбаатар

Энэхүү гэрээг нэг талаас тоот хаягт байрлалтай, тоот регистрийн дугаартай “.....” ХХК (Цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал, нөгөө талаас тоот байрлах “.....” ХХК (Цаашид “Гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал(Хамтад нь “Талууд”гэх) нар Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Гүйцэтгэгч нь нутаг дэвсгэрт орших “.....” ХХК-ийн барилгын гадна цахилгааны шугам татах, шилжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.
/цаашид “Ажил” гэнэ/Үүнд:

1.1.1 Гадна цахилгааны 0.4 кВ шугам татах, барилгын ерөнхий шитэнд холбох

1.1.2 0.4 кВ шугамыг өөрийн ХТП-ийн барилгыг тойруулж шилжүүлэн холбох

1.2 Гүйцэтгэгч нь цахилгаан угсралтын ажил хийж байсан туршлагатай, барилгын талбай дээр ажиллах ИТА-тай болохоо үүгээр баталж байна.

1.3 Энэхүү гэрээ нь дараах хавсралтаас бүрдэнэ. Үүнд:

1.3.1 Ажлын тоо хэмжээ, төлбөрийн задаргаа

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1-т заасан ажлыг-ний өдрөөс-ний өдрийг хүртэл буюу хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

2.2. Гүйцэтгэгчийн энэхүү гэрээний 2.1 дэх хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэх ажлын ажилбар бүрд Захиалагчийн инженер хяналт тавих бөгөөд Захиалагчийн Инженерийн зааварчилгаагаар ажилбар бүрийн хугацааг тогтооно.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Захиалагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

3.1.1. Гэрээний төлбөрийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэх болон инженерийн гүйцэтгэлийн тайланд үндэслэн төлөх

3.1.2. Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах зураг төсөл, бичиг баримт болон бусад мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөх.

3.1.3. Барилгын ажлын ерөнхий гэрэлтүүлгээр хангах

3.2. Захиалагч нь дараах эрхтэй. Үүнд:

- 3.2.1. Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэж буй ажлын явцтай танилцах, хяналт тавих, шаардлага гаргах
- 3.2.2. Гүйцэтгэгчийн нийлүүлсэн бараа материал нь зураг төсөл болон холбогдох чанар стандартад нийцэж байгаа эсэх болон ажлын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавих, шаардлага хангахгүй бараа материалыг солихыг шаардах, шаардлага хангахгүй байгаа ажлыг дахин хийхийг шаардах
- 3.2.3. Гүйцэтгэгчээс гэрээний дагуу бүрдүүлсэн бичиг баримтыг хугацаанд гаргаж өгөхийг шаардах

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

- 4.1.1. Гэрээт ажлыг энэхүү гэрээнд заасан хугацаанд багтаан аюул осолгүй, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх.
- 4.1.2. Бараа материалын татан авалтыг цаг хугацаанд нь гүйцэтгэх
- 4.1.3. Шугам шилжүүлэхтэй холбоотой геодезийн хэмжилт, газар доор шугам чагнах зэрэг мэргэжлийн байгууллагын ажлыг хариуцан гүйцэтгүүлэх, шаардлагатай төлбөрийг төлөх.
- 4.1.4. Шугам шилжүүлэх, таслах, холбох зэрэг УБЦТС-ээс авах шаардлагатай зөвшөөрлийг Захиалагчийн нэрийн өмнөөс хүсэлт гаргаж, авсан байх.
- 4.1.5. Гүйцэтгэсэн ажилтай холбоотой байр зүйн зургийг Захиалагчийн нэрийн өмнөөс мэдээллийн санд оруулах.
- 4.1.6. Өөрийн татан авсан бараа материалыг тээвэрлэж, барилгын талбайд буулгаж хураах, шаардлагатай хэсэгрүү зөөвөрлөх, зөөвөрлөхөд шаардлагатай тоног төхөөрөмж, хүн хүчээр хангах
- 4.1.7. Гүйцэтгэсэн ажил нь чанарын шаардлага хангахгүй дутуу гүйцэтгэсэн нь тогтоогдвол чанаргүй, дутуу гүйцэтгэсэн ажлыг захиалагчийн тогтоосон хугацаанд өөрийн зардлаар засварлах, нөхөн гүйцэтгэх.
- 4.1.8. Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх явцдаа нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой аливаа хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх, шаардлагатай тохиолдолд өөрсдийн ажилчдаа даатгалд хамруулах
- 4.1.9. Гэрээт ажлын хүрээнд ХАБЭА-н асуудлыг дангаар хариуцах
- 4.1.10. Гүйцэтгэгчийн инженер нь захиалагч талын инженертэй харилцаж заавар, зөвлөмж авах ба мэдээллийг тухай бүрд ажилчдад тогтмол дамжуулж ажлыг чанартай, заасан хугацаанд гүйцэтгүүлэх
- 4.1.11. Ажлыг гүйцэтгэхдээ ажлын талбайт ИТА-аас гаднахүн тогтмол ажиллуулна.
- 4.1.12. Тухайлсан ажлын гэрэлтүүлгийг хариуцах

- 4.1.13. Өөрийн багаж, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцах ба хэрвээ битүү сав, агуулахад хийж цоожилж лацадсан тохиолдолд харуул хамгаалалтын ажилтанд хүлээлгэн өгч болно.
- 4.1.14. Өдөр тутмын ажлын хүрээнд орчноо цэвэр байлгах
- 4.1.15. Ажил гүйцэтгэхтэй холбоотой бүхий л бараа материал тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслээр хангах
- 4.1.16. Сар бүр Захиалагчийн инженерээр гүйцэтгэсэн ажлаа баталгаажуулах
- 4.2. Гүйцэтгэгч нь дараах эрхтэй. Үүнд:
 - 4.2.1. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай бичиг баримт болон бусад мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөхийг шаардах
 - 4.2.2. Захиалагч чанарын шаардлага хангасан ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож гэрээний төлбөр төлөхийг захиалагчаас шаардах.
 - 4.2.3. Сар бүр гүйцэтгэсэн ажлын хэмжээгээр төлбөр авах

ТАВ. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР БА ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

- 5.1. Энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт төлбөр нь (.....) төгрөг байна. Дээрх үнийн дүнд тус ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бүхий л зардал болон НӨАТ шаардлагатай бүхий л татвар хураамж орсон болно. Гэрээний нийт төлбөрийг өөрчлөхгүй байхаар талууд харилцан тохиролцов.
- 5.2. Гүйцэтгэх ажлын төлбөрийн задаргааг энэхүү гэрээний хавсралтаар баталгаажуулсан болно.
- 5.3. Захиалагч нь гэрээний урьдчилгаа төлбөрт (.....) төгрөгийг энэхүү гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор Гүйцэтгэгчийн банкны..... тоот дансанд төлнө.
- 5.4. Гүйцэтгэгчийн үлдэгдэл төлбөрийг гэрээт ажлыг Захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор Захиалагчийн инженерийн гүйцэтгэлийн тайлан, Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг тус тус үндэслэн төлнө.
- 5.5. Энэхүү гэрээний үнийн дүнгийн 5%-тай тэнцэх хэмжээний мөнгөн дүн болох ... төгрөгийг Гүйцэтгэлийн баталгаа хэлбэрээр Захиалагч нь суутган барьж үлдэнэ.
- 5.6. Гүйцэтгэлийн баталгааг Захиалагч нь барилгыг улсын комист хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд барьж үлдэх бөгөөд Гүйцэтгэгч тус хугацаанд гарсан доголдлыг арилгаагүй, ажилаа дутуу хийж гүйцэтгэх тохиолдолд тухайн баталгаанаас зарцуулж болох бөгөөд гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Хэрвээ тус хугацаанд зарцуулаагүй тохиолдолд хугацаа дууссанаас хойш ажлын 2 хоногийн дараа Гүйцэтгэгчийн данс руу шилжүүлнэ.

ЗУРГАА. АЖЛЫГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

- 6.1. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох норм дүрэм болон энэхүү гэрээнд заасны дагуу гүйцэтгэх бөгөөд Захиалагч цахилгааны холболт хийн, шалгаж хүлээн авна.

- 6.2. Талууд ажлыг бүрэн гүйцэтгэж дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан шалган хүлээн авах бөгөөд Захиалагчийн инженер гүйцэтгэлийн тайлан үйлдэж, актаар баталгаажуулан хүлээлгэн өгнө.
- 6.3. Хүлээлгэн өгөх явцад алдаатай, чанарыг шаардлага хангахгүй нь тогтоогдсон тохиолдолд гүйцэтгэгч өөрийн зардлаар дутуу, чанаргүй гүйцэтгэсэн ажлыг дахин хийж гүйцэтгэнэ. Ийнхүү хугацаа хожимдсон нь энэхүү гэрээний 7 дугаар зүйлд заасан алданги төлөх үндэслэл болно.
- 6.4. Актаар баталгаажуулсан тохиолдолд шавардлагын ажлыг хүлээлгэн өгсөнд тооцно.
- 6.5. Цахилгааны ажлын чанарын баталгаат хугацаа хүлээлгэн өгснөөс хойш 2 жил байна.
- 6.6. Чанарын баталгаат хугацаанд үүссэн аливаа гэмтлийг Гүйцэтгэгч дангаар хариуцна.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 7.1. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг энэхүү гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх хэмжээний алдангийг Захиалагчид төлнө.
- 7.2. Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй, дутуу төлсөн бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 7.3. Гүйцэтгэгч нь гуравдагч этгээдийн хийж гүйцэтгэсэн ажлыг гэмтээсэн, хохирол учруулсан тохиолдолд үүссэн хохирлыг дангаар барагдуулж, Захиалагчийг хохиролгүй болгоно.
- 7.4. Үндсэн хийцийн угсралтын буруугаас үүссэн доголдол, энэхүү гэрээнд зааснаас бараа материал, угсралтын ажил зөрсөн нь тогтоогдсон тохиолдолд зардлыг Гүйцэтгэгч дангаар хариуцах бөгөөд Захиалагчид учирсан хохирлыг нөхөн төлнө.
- 7.5. ХАБЭА-н тухай хууль тогтоомж норм дүрэм баримтлаагүйгээс үүссэн хохирол, нөхөн төлбөрийг Гүйцэтгэгч дангаар хариуцах бөгөөд Захиалагчийг ангид байлгана.
- 7.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлын хугацааг хоцроосон, дутуу, чанаргүй гүйцэтгэсэн нь тогтоогдсон тохиолдолд Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцална. Ийнхүү гэрээ цуцлагдсан тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчид учирсан эд хөрөнгийн хохирол болон хугацааны хоцрогдлоос шалтгаалсан хохирол зэргийг нөхөн төлнө.
- 7.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлнө.
- 7.8. Алданги төлсөн нь талуудыг гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

НАЙМ. БУСАД ЗААЛТ

- 8.1. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүргээ нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 8.2. Гэрээт ажлын чанарын талаарх гомдлыг гүйцэтгэгч тал зөвшөөрөхгүй бол мэргэжлийн хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулж болно.

- 8.3. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээрийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн дэргэдэх Барилга, Дэд бүтцийн Олон Улсын Арбитраар түүний хэрэг хянан шийдвэрлэх дүрмээр шийдвэрлүүлнэ.
- 8.4. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээгээр тогтоосон хугацаат ажил дууссанаар дуусгавар болно.
- 8.5. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талуудад тус бүр нэг нэг хувийг хадгалуулав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

.....

Гүйцэтгэгчийг төлөөлж:

.....

Хавсралт – 1 /Ажлын тоо хэмжээний задаргаа/

№	Тодорхойлолт	Техникийн шаардлага	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал				
					Материал	Цалин	Тээвэр	Тоног.төх	Нийт үнэ
14									